

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: 2024 онд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийх ажлуудын эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг энэ ондоо багтаан зохион байгуулах.				
1	<p>Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 16 дугаар тогтоолын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны 69 төлөвлөгөөг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Сангийн яам, Төрийн Худалдан авах ажиллагааны газар, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газруудад тус тус хүргүүлэн www.tender.gov.mn цахим системд байршуулан ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоол гарсантай холбогдуулан Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж Сангийн яам, Төрийн Худалдан авах ажиллагааны газар, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газруудад тус тус хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>			70
Үүрэг даалгавар ХОЁР: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ “Шинэ жил”-ийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл хийх ажлуудаа эрчимжүүлж, энэ долоо хоногт багтаан дуусгах				
2	<p>Шинэ жилийн баяртай холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэрэлтүүлэг бүхий тохижилт хийж, ая тухтай орчныг бүрдүүлэх талаар дүүргийн Засаг даргын орлогчийн “Хамтран ажиллах тухай” 2/3091 тоот албан бичгийг “Макс Хотелс” ХХК, “Скайтэл” ХХК, 5 дугаар хороо Самбуугийн гудамжинд үнэт эдлэлийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 нийт 6 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн 4 дүгээр хороо Анкарагийн гудамжинд хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 23 байгууллагад шинэ жилийн баяртай холбоотойгоор гадна орчиндоо гэрэлтүүлэг бүхий тохижилтыг 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор хийх талаар мэдэгдсэн бөгөөд хэрэгжилтийг хангасан.</p> <p>“Шинэ жилийн худалдаа” арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс дүүргийн 5 дугаар хороо, Тусгаар тогтнолын талбай дээр нийт 8 худалдаа, үйлчилгээний</p>			90

	газрыг нэгдсэн стандартын дагуу үйл ажиллагаа явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			
Үүрэг даалгавар ГУРАВ: Нийслэл, дүүргүүдэд /E-doc, E-gazar/ системээр ирсэн газрын өргөдлийг судалж, шийдэх.				
3	1.Тус албаны E-doc системд 1883 албан бичиг ирснээс 1868 албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 20 албан бичиг судлах шатандаа явж байна. E-gazar-т цахим системд 280 хүсэлт ирснийг бүрэн шийдвэрлээд байна.Үүнд: ✓ Материалын бүрдэл бүрэн хангасан 18 хүсэлтэд цахимаар үйлчилгээ үзүүлсэн. ✓ Бүрдүүлэх материалын жагсаалт дутуу илгээсэн 262 хүсэлтэд зөвлөгөө мэдээлэл илгээсэн.			90
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Хөрөнгө оруулалтын ажлуудын явцыг танилцуулж, дүүрэг рүү захиалагчийн хяналтыг шилжүүлэх ажлын бэлтгэл хангах.				
4	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих 24 ажлыг Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв гүйцэтгэлээ. Үүнээс: ➢ 100 хувийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан-20. ➢ 90 хувийн гүйцэтгэлтэй-3 ➢ Ажлын зураг батлагдаагүй-1 ажил тус тус байна.			90
Үүрэг даалгавар ТАВ: 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт түншлэлээр хийгдэх ажлуудын жагсаалтыг гаргаж Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэст ирүүлэх.				
5	Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт эрх шилжин ирж байгаа ажлуудын жагсаалт Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас албан ёсоор баталгаажуулан ирээгүй байна.			90
Үүрэг даалгавар ЗУРГАА: Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр контентуудыг бэлтгэж олон нийтэд хүргэх ажлуудыг шуурхай зохион байгуулах.				
6	“Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах” ажлын төлөвлөгөөний дагуу галлагааны улирал эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн 7-24 дүгээр хорооны угаарын хийн хордлогод өртөх эрсдэлтэй айл өрх, иргэдэд сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэх, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, угаарын хий мэдрэгчийн хэрэглээ зэрэг зөвлөмжийг нийт 9893 өрхөд хүргүүлсэн. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасгаас хүйтний уририал эхэлсэнтэй холбогдуулан агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудас, Чингэлтэй дүүрэг пэйж хуудсаар 5 удаагийн мэдээлэл, контент хүргэн ажилласан. Тус мэдээллүүд нийт 101 хүнд таалагдсан, 96 удаа хуваалцсан байна.			90
Үүрэг даалгавар ДОЛОО: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, иргэд олон нийтийг маск зүүхийг уриалж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажлаа эрчимжүүлж, Эрүүл мэндийн харьяа байгууллага болон өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулах.				

7	<p>Эрүүл мэндийн яамны сайдын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай” А/361 дүгээр тушаалын дагуу:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 4-6 дугаар хорооны хүүхдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт ➢ 1-3, 7-9, 12 дугаар хорооны хүүхдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг Халдварт өвчин судлалын үндэсний төв эмнэлэгт шилжүүлсэн ба насанд хүрэгчдийн мэдрэлийн тусламж үйлчилгээг Улсын нэгдүгээр төв эмнэлэгт. ➢ 8, 12, 16-18, 21 дүгээр хорооны насанд хүрэгчдийн дотрын тусламж үйлчилгээг Улсын гуравдугаар эмнэлэгт хүргүүлэн эмчлүүлж байна. <p>Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын А/148 дүгээр тушаалын дагуу 1-7, 19, 24 дүгээр хорооны насанд хүрэгчдийн дотрын эмгэгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг СХДЭМТ-д шилжүүлсэн.</p> <p>Томуу, томуу төст өвчний идэвхжил нэмэгдсэнтэй холбогдуулан нийт хүүхдийн тасгийн 80 орыг төлөвлөгөөний дагуу нэмэгдүүлэн дотрын тасгийн 41 орыг хүүхдийн тасагт нэмэлтээр 20 ор, нийт 141 ор дэлгэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. 2023 оны 12 сарын 19-ний өдрийн байдлаар 151 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.</p> <p>НЭМГ-н 2023 оны 12 сарын 06-ны А/203, А/204 тоод тушаалаар эрүүл мэндийн төвийн амбулатори ажлын өдрүүдэд 17:00-21:00 цаг хүртэл, амралтын өдөр Бямба гарагт 12:00-18:00 цаг хүртэл, өрхийн эрүүл мэндийн төвүүд ажлын өдөр 08:30-20:00 цаг хүртэл, амралтын өдөр 10:00-15:00 цаг хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна. 12 сарын 19-ны байдлаар уртасгасан цагаар амбулаторид 132 хүүхэд тусламж үйлчилгээ авсан бол Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд уртасгасан цагаар ажиллах үед 228 иргэн тусламж үйлчилгээ авсан байна.</p> <p>Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн амбулаторийн 3 салбарт иргэдэд Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг 1520 өгөн, 4560 ширхэг тараах материал тараан ажилласан</p> <p>Хүүхдийн байгууллагын 35 эмч нартай цаг үеийн нөхцөл байдлын талаар 1 удаа хуралдаж, хүүхдүүдэд ирцийн тандалт хийн, шалтгааныг тодруулан ажилласан.</p> <p>Дүүргийн 1-24 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдэд томуутай холбоотой тушаал зааврыг хүргүүлэн 50 эмч, 65 сувилагч нарт эрэмбэлэн ангилалтын талаар сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Томуугаас сэргийлье” вакцины 10 хоногийг зохион байгуулах Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/358, НЭМГ-ын даргын 2023 оны А/149 дүгээр тушаалын дагуу дүүргийн хэмжээнд томуугийн дархлаажуулалтыг гүйцэтгэх, дүүргийн ЭМТ-ийн даргын А/160 дугаар тушаалыг батлуулан 2023 оны 10 дугаар сарын 10-20-ны өдрийн хооронд хэрэгжүүлж байна. 2023 оны 10 сараас эхэлсэн улирлын томуугийн эсрэг вакцинд 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар эрсдэлт бүлгийн 12,460 иргэн хамрагдахас 10,217 иргэн хамрагдан 82 хувьтай байна.</p>			90
---	--	--	--	----

Үүрэг даалгавар НАЙМ: Соёл урлагийн байгууллагууд шинэ жилийн шинэлэг контентуудыг хийх, соёлын хандлагыг өөрчлөх ажлуудыг зохион байгуулж, “Эвент” зохион байгуулах жагсаалт гаргах.			
8	<p>Дүүргийн нутаг дэвсгэр СУИС-иас Анкарагийн гудамж хүртэл зам дагуу гэрлэн чимэглэлийг засаж шинэчилсэн. Тусгаар тогтнолын талбайд сүлд мод засан, Мөсөн хотхон (мөсөн коток, өвлийн өвгөн, цасан охин, бугатай чарга, мөсөн хана, мөсөн гулгуур- бага, дунд насны ангиллаар, пороро, минион, луу) байгуулсан.</p> <p>Тусгаар тогтнолын талбайд 12 дугаар сарын 27-ны өдөр Өсвөрийн шигшээ багийн үзүүлэх тоглолт, 12 дугаар сарын 30-ны соёл, урлагийн тоглолт, шинэлэг эвент хийхээр тус тус төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>		90
Үүрэг даалгавар ЕС: 2024 онд жуулчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж танилцуулах.			
9	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт Чингис хаан музей, Байгалийн түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Үндэсний түүхийн музей үйл ажиллагаа явуулдаг. Музейг гадаад дотоодод сурталчилж, олон талт арга хэмжээг төлөвлөж Засаг даргын Тамгын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэж байна.</p> <p>Чингис хаан Үндэсний музейн “Музейд суралцахуй” боловсролын цогц хөтөлбөр нь музейн үзмэр, үзүүлдэгт тулгуурлан, бүтээлч танин мэдэхүйн үйл ажиллагаагаар дамжуулж үзэгчдийн насны онцлогт тохируулан 7 төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах 7 төрлийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Хүннүгийн Бэлгэт гөрөөс урлая” баримлын шавар урлалын хөтөлбөр; 2. "Буган чулуун хөшөө цутгаж хийх" баримлын хөтөлбөр; 3. "Шороон бумбагарын цагаан бар, бунхны хамгаалагч домгийн амьтан зурах" уран зургийн хөтөлбөр; 4. “Их Монгол улсын үеийн язгууртны дээлийг цаасаар урлахуй” цаасан нугалбарын хөтөлбөр; 5. “Монголын эзэнт гүрний үеийн хаад язгууртны малгай хийж өмсөх” эсгий урлалын хөтөлбөр; 6. “Хоригийн өрөмтэй ваарыг урлах нь” ваар урлалын хөтөлбөр; 7. “Сарьдагийн хийдийн язгуурын таван бурхан”-ыг элсээр хэвлэх хөтөлбөрийг тус тус хамтран хэрэгжүүлж гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтыг тавьж, Засаг даргын Тамгын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэж байна. 		90

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
НЭГТГЭСЭН:

Э.ХУЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ